

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 8-р сарын 11-ны өдрийн 388 тоот тушаалын Хавсралт

БАНКИНД ОНЦГОЙ ДЭГЛЭМ ТОГТООХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.Энэхүү журмын зорилго нь Банкны тухай хуулийн 6 дугаар бүлэгт заасны дагуу Банкинд онцгой дэглэм тогтоохтой холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.

2.Энэхүү журамд хэрэглэгдэх нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.

1/"Онцгой дэглэм тогтоох" гэж Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлд зааснаар Монголбанкны шийдвэрээр тухайн банкны хэвийн үйл ажиллагааг хангах, санхүүгийн байдлыг нь сайжруулах зорилгоор банкийг өөрчлөн байгуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх буюу удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн болон холбогдох бусад арга хэмжээг цогцолбороор нь авахыг хэлнэ.

2/"Банкийг өөрчлөн байгуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх" гэж Банкны тухай хуулийн 361 зүйлийн 2 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйлд зааснаар банкны активийг бусад этгээдэд худалдах, дүрмийн санг өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөх хэмжээнд хүртэл нэмэгдүүлэх, банк түүний нэгжийг худалдах, банкийг өөрчлөн байгуулах болон бусад шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэхийг хэлнэ.

3/"Бүрэн эрхт төлөөлөгч" гэж Банкны тухай хуулийн 35 дугаар зүйлийг үндэслэн онцгой дэглэм тогтоох албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхээр Монголбанкнаас томилсон Монголбанкны ажилтан болон иргэн, хуулийн этгээдийг хэлнэ.

ХОЁР. Онцгой дэглэм тогтоох үндэслэл

3.Монголбанк нь банкинд дараахь үндэслэлээр онцгой дэглэм тогтоох арга хэмжээ авна:

1/Банк нь Банкны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,2-т заасан шаардлагын аль нэгийг Монголбанкнаас тогтоосон журмын дагуу зохих хэмжээ, хэлбэрээр хангаагүй, төлбөрийн чадваргүй болж болзошгүй нь Монголбанкны ээлжит болон мэдээллийн дагуу хийсэн

хяналт шалгалтаар тогтоогдсоноос хойш 3 сарын хугацаанд зөрчлийг засч, үзүүлэлтийг хангаагүй бол;

2/Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох журмын дагуу тооцож үзэхэд банк нь өөрийн хөрөнгө, нийт цэвэршүүлсэн активийн харьцааны түвшингээр “өөрийн хөрөнгө нь туйлын хангалтгүй байгаа” ангилалд хамаарч байгаа.

4.Банкны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-т заасан шаардлагад дараахь шалгуур үзүүлэлт хамаарна. Үүнд:

1/заавал байлгах нөөцийн хангалтын хувь хэмжээ;

2/өөрийн хөрөнгийн хүрэлцээ /дүрмийн сангийн хэмжээ, өөрийн хөрөнгө, нийт активийн зохистой харьцааны биелэлт/;

3/төлбөр түргэн гүйцэтгэх чадвар /төлбөр түргэн гүйцэтгэх чадварын шалгуур үзүүлэлт, хадгаламж эзэмшигч, харилцагчдын анхны шаардлагаар мөнгөн хөрөнгийг нь гаргаж өгч байгаа эсэх/;

4/зээлийн багцын чанар, зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сангийн хүрэлцээ, хангамж;

5/гадаад валютын позицгийн болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.

ГУРАВ. Онцгой дэглэм тогтоох шийдвэр,

Бүрэн эрхт төлөөлөгч томилох

5.Банкны үйл ажиллагаанд энэ журмын 2 дугаар бүлгийн 3 дахь хэсэгт заасан үндэслэл бий болсон тохиолдолд тухайн банкинд онцгой дэглэм тогтоох арга хэмжээ авах тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэр гарна.

6.Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрээр Бүрэн эрхт төлөөлөгч буюу бүрэн эрхт төлөөлөгчийн зөвлөл /цаашид БЭТ гэнэ/ - ийг томилох бөгөөд шаардлагатай гэж үзвэл түүнийг өөрчлөх буюу ажиллах хугацааг нь сунгаж болно.

7.БЭТ нь Монголбанкны өөрийн ажилтан болон банкны ажлын дадлага туршлагатай иргэн, хуулийн этгээд байж болно. Хэрэв хуулийн этгээд бол түүний томилсон этгээд нь хуулийн этгээдийн төлөөллийг бүрэн хэрэгжүүлэх эрх бүхий этгээд байна.

8.Онцгой дэглэм тогтоон хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааны зардлыг тухайн банк хариуцна. БЭТ нь өөрийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг тухайн банкны төвд төвлөрсөн журмаар тусгай дансанд, зүйл анги тус бүрээр нь бүртгэх бөгөөд хөдөө орон нутгийн салбаруудын үйл ажиллагаатай холбогдон гарсан зардлыг орон нутагт БЭТ-ийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа этгээд банкны төвөөс нэхэмжлэн авч байна.

9.Онцгой дэглэм тогтоосон банкны орон нутаг дахь нэгжийн өдөр тутмын ажиллагаанд тухайн орон нутаг дахь Монголбанкны захирал хяналт тавьж ажиллана.

10.Бүрэн эрхт төлөөлөгчид тавих шаардлага:

1/эдийн засаг эсвэл эрх зүйн дээд боловсролтой, ажлын туршлагатай, ёс зүйн төлөвшилтэй байх;

2/ял шийтгэлгүй байх;

3/тухайн банкинд зээлийн өргүй байх;

4/БЭТ, түүний зөвлөлийн гишүүд нь Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасан "холбогдох этгээд" биш байх;

5/банкны ажлын зохих мэдлэг, дадлага туршлагатай байх;

11.Хуулийн этгээдийн хувьд энэ журмын 10 дугаар зүйлд зааснаас гадна дор дурьдсан нэмэлт шаардлагыг хангасан байна.

1/тухайн банкны алдагдлыг бууруулах, хэвийн үйл ажиллагааг нь хангахад хүрэлцэхүйц хэмжээний санхүүгийн эх үүсвэртэй, шаардлагатай үнэт цаас, санхүүгийн бусад баталгаагаар хангаж чадах чадвартай байх;

2/банкны санхүүгийн үйл ажиллагааг хэвийн ажиллуулж чадах туршлагатай нь урьд болон одоо эрхэлж байгаа үйл ажиллаганы үр дүнгээр тодорхойлогдсон байх;

3/тухайн хуулийн этгээдийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, татвар төлсөн байдлын талаарх татварын газрын тодорхойлолт;

12.БЭТ-ийг томилон ажиллуулахтай холбоотой бусад нөхцлийг Монголбанкнаас БЭТ-тэй байгуулах гэрээнд нарийвчлан тусгана.

13.БЭТ нь үйл ажиллагаандаа тамга тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

14.Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т заасны дагуу БЭТ-ийн ажиллах хугацаанд тухайн банкны төлбөрийн чадварт гарсан хүндрэл нь банкны тогтолцоо, төлбөр тооцооны тогтолцооны шинж чанартай эрсдэлийг үүсгэж болзошгүй нөхцөл байдлыг бий болгосон гэж Монголбанк үзвэл өөрчлөн байгуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэй, түр хугацааны зээл олгож болно.

15.Онцгой дэглэм тогтоосноор банкны санхүү, төлбөрийн чадварын байдалд үр дүн гараагүйгээс банкныг албадан татан буулгах тохиолдолд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд зориулан олгосон зээлийг Банкны тухай хуулийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан төлбөр барагдуулах дарааллыг баримтлан тооцож, буцаан төлүүлнэ.

ДӨРӨВ. Бүрэн эрхт төлөөлөгчийн эрх үүрэг, авч хэрэгжүүлэх арга хэмжээ

16.Онцгой дэглэм тогтоосон банкны удирдлагын бүрэн эрх нь БЭТ-д шилжинэ.

17.БЭТ нь Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан эрх хэмжээний хүрээнд онцгой дэглэмийг хэрэгжүүлэхдээ дор дурьдсан үүрэг хүлээнэ.

1/өөрийн үйл ажиллагаандаа Банкны тухай болон бусад холбогдох хууль тогтоомж, Монголбанкнаас баталсан эрх зүйн актыг мөрдөх;

2/томилогдсоноосоо хойш 14 хоногийн дотор тухайн банкны санхүү, төлбөрийн чадварын байдалд өөрийн дүгнэлтийг бичиж, /Дүгнэлтэнд нотлох баримтыг хавсаргаж баталгаажуулна./ авах арга хэмжээний талаарх саналыг Монголбанкинд өгөх;

3/цаашид банкны үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварыг сайжруулах талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ буюу өөрчлөн байгуулах төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын талаар 14 хоног тутам Монголбанкны Ерөнхийлөгчид бичгээр тайлагнах;

Монголбанкны Ерөнхийлөгч шаардлагатай гэж үзвэл тайланг Монголбанкны Бодлогын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж болно.

18. БЭТ нь дараахь арга хэмжээг авна. Үүнд:

1/тухайн банкинд онцгой дэглэм тогтоосон тухай Монголбанкны шийдвэрийг банкны удирдлага, нийт ажиллагсдад танилцуулж, энэ тухай

мэдэгдлийг тухайн банкны бүх газар, хэлтэс, салбар нэгжид өгөх;

2/шаардлагатай гэж үзвэл онцгой дэглэмийг хэрэгжүүлж байгаа талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх;

3/банкны бүх үйл ажиллагаатай холбоотой асуудлаар бие даан шийдвэр гаргаж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, тухайн банкны хувь нийлүүлэгч, ТУЗ, Гүйцэтгэх захирал, газар, хэлтэс, салбар, нэгжийн удирдлагын бүрэн эрхийг түдгэлзүүлсэн тухай хадгаламж эзэмшигч, харилцагчдад мэдэгдэх;

4/банк, түүний нэгжийн бүх эд хөрөнгө, баримт бичгийг хяналтдаа авах;

5/банкны нэрийн өмнөөс үйл ажиллагаа эрхлэх ажилтнуудын тоог хязгаарлах, бусад ажилтны банкны эд хөрөнгийн ашиглах, захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлэх;

6/онцгой дэглэм тогтоосон тухай шийдвэр гарсан өдрөөр тасалбар болгон тус банкны гүйлгээг хааж, орлого, зарлагын тайлан тэнцлийг /тухайн өдрийн байдлаар/ гаргуулан, банкны гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогчоор гарын үсэг зуруулж, тамга тэмдэг даруулах;

7/банкны гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, дотоод хяналтын ба бусад газар, хэлтэс, салбар, нэгжийн захирлуудын албан үүргээ гүйцэтгэх хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг авах;

8/онцгой дэглэм тогтоосон банкны орон нутаг дахь салбаруудад тухайн орон нутаг дахь Монголбанкны салбараас баримталж ажиллах удирдамж, чиглэлийг Монголбанкны зөвшөөрсөнөөр Хавсралт 1-ийн дагуу боловсруулж, хүргүүлэх;

9/онцгой дэглэм тогтоох тухай шийдвэр гарсан өдрийн тайлан тэнцэлд судалгаа хийж, банкны үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварын байдалд нь дүгнэлт гаргах;

10/тайлан тэнцлийн холбогдох дансдын үлдэгдэл үндсэн баримттай зөрвөл, энэ талаар тухайн банкны удирдлага, холбогдох бусад этгээдэд мэдэгдэж, зөрүүг тохируулах, баримтжуулах, холбогдох байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх.

19. БЭТ нь бэлэн мөнгө, баримт бичиг, тайлан тэнцлийн баримтыг дараахь

байдлаар гаргуулан авна. Үүнд:

1/сейф, агуулах, бусад хайрцаг, сав, цүнх автомашинд байгаа болон бусад газраас хүлээн авсан бэлэн мөнгө, тоолж буй мөнгө, адилтгах бусад зүйлс /үнэт металл, эрдэнийн чулуу, тусгай буюу замын чек, зээллэгээ, үнэт цаас, үнэт эдлэл/;

2/зээлийн хувийн хэрэг: зээл олгохыг хүссэн өргөдөл, зээлийн гэрээ, зээлийн барьцаанд бариулах эд хөрөнгийн тодорхойлолт, үнэлгээ болон уг хөрөнгийг эзэмших эрхийн бичиг, түүнийг шалгасан баримт, зээлийн батлан даалт, батлан даагчийн бүртгэл, судалгаа, зээлийн зарцуулалт, эдийн засгийн үр ашгийн тооцоо, санхүүгийн тайлан, зээлийн ашиглалт шалгасан материал, бусад шаардлагатай баримт бичиг;

3/үндсэн хөрөнгө, эд хогшлын хяналтын карт, бүх үл хөдлөх хөрөнгө болон хөдлөх хөрөнгө, тэдгээрийн өмчлөх гэрчилгээ, /тээврийн хэрэгслэл, түүний эрхийн үнэмлэх/;

4/өр, авлагын холбогдолтой баримт бичиг, /банк хоорондын гүйлгээний үлдэгдлийн жагсаалт, шилжүүлгийн жагсаалт, аж ахуйн нэгж байгууллага, хүмүүстэй хийх төлбөр тооцооны жагсаалт/;

5/хадгаламжийн болон харилцах дансны хяналтын карт, гарын үсгийн баталгаа;

6/банк, түүний нэгжийн нэгдсэн тайлан тэнцэл;

7/даатгалын баримт бичиг, нягтлан бодох бүртгэлийн маягт;

8/хувь нийлүүлэгчдээс банкны дүрмийн санд оруулсан хөрөнгийн жагсаалт;

9/банкны ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх, орлогч захирлууд болон бусад удирдах ажилтнуудын гарын үсэгтэй гадагш явуулсан албан бичиг, тоот;

10/тухайн банкинд мөрдөгдөж байсан болон мөрдөгдөж буй журам, заавар;

11/шаардлагатай бусад тайлан мэдээ, материал.

20.БЭТ-ийн үйл ажиллагаатай холбогдсон бусад асуудлыг Монголбанкнаас БЭТ-тэй байгуулах гэрээнд нарийвчлан тусгана.

ТАВ. Банкийг өөрчлөн байгуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх

21.БЭТ нь онцгой дэглэм тогтоосноос хойш 30 хоногийн дотор Банкны тухай хуулийн 36¹ дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 18 - 23 зүйлийг үндэслэн банкийг өөрчлөн байгуулах төлөвлөгөөг боловсруулж, Монголбанкинд ирүүлнэ.

22.Монголбанк нь банкийг өөрчлөн байгуулах төлөвлөгөөг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж батална.

23.Банкийг өөрчлөн зохион байгуулахтай холбогдуулан Банкны тухай хуулийн 36¹ дугаар зүйлд зааснаас гадна төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгана.

1/авлага, өглөгийн тооцоо, хөрөнгийн дахин үнэлгээ;

2/банкнаас бусад этгээдтэй хийсэн гэрээ, хэлцлийг шийдвэрлэх арга зам;

3/хувьцаа, ногдол хувь, хөрөнгө шилжүүлэх хувь хэмжээ, харьцаа, хуваарилах арга;

4/банкийг өөрчлөн зохион байгуулснаас гарах үр дүнгийн тооцоо, банкны тайлан тэнцэл;

5/банк нь бусад банктай нэгдэж, нийлж байгаа болон хувааж, тусгаарлаж байгаа, эсвэл дүрмийн сангийн бүтэц, хэмжээнд өөрчлөлт орж байгаа бол өөрчлөн зохион байгуулагдсаны үр дүнд үүсч бий болох банкны эрхлэх үйл ажиллагаа, ажил үйлчилгээний төрөл, хэлбэр, эрх үүрэг;

6/өөрчлөн зохион байгуулагдсаны үр дүнд үүсч бий болох банкны дүрэм, хэрэв өөр банктай нийлж байгаа бол тухайн банкны дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт;

7/өөрчлөн зохион байгуулагдсан банкны бизнес төлөвлөгөө.

24.БЭТ нь банкийг өөрчлөн зохион байгуулахтай холбогдуулан авах арга хэмжээний төлөвлөгөөг дараахь арга замаар хэрэгжүүлнэ:

1/банкны дүрмийн санг өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөх хэмжээнд хүртэл нэмэгдүүлэх;

2/чанаргүй активыг бэлэн мөнгө буюу түргэн борлогдох үнэт цаасны хэлбэрээр сайн чанарын активаар борлуулах, эсвэл сонирхогч иргэн, хуулийн этгээдэд худалдах;

3/шаардлагатай бол банк, түүний нэгжийг сонирхогч этгээдэд худалдах;

4/дүрмийн сангийн бүтэц, хэмжээг өөрчлөх;

ЗУРГАА. Онцгой дэглэм тогтоох арга хэмжээг дуусгавар болгох

25.Өөрчлөн байгуулах төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Монголбанкны Бодлогын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, дор дурьдсан нөхцөл бүрдсэн гэж үзвэл онцгой дэглэм тогтоох арга хэмжээг дуусгавар болгож, банкинд тогтоосон хязгаарлалтыг бүрмөсөн, эсвэл хэсэгчлэн хүчингүй болгоно:

1/онцгой дэглэм тогтоосноор тухайн банкны хэвийн үйл ажиллагаа хангагдсан;

2/онцгой дэглэм тогтоосноор банкны хэвийн үйл ажиллагаа хангагдаагүй бол Монголбанкнаас тухайн банкинд эрх хүлээн авагч томилсон.

26.Өөрчлөн байгуулах төлөвлөгөө амжилттай хэрэгжиж, Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, заавал байлгах нөөц, гадаад валютын позици болон зээлийн төвлөрлийн эрсдэлийн шалгуур үзүүлэлтүүдийг тогтвортой хангаснаар Монголбанк тухайн банкны хэвийн үйл ажиллагааг хангагдсан гэж үзнэ.

ДОЛОО. Хариуцлага

27.Энэ журмыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**ОНЦГОЙ ДЭГЛЭМ ТОГТООСОН БАНКНЫ ОРОН НУТАГ ДАХЬ
САЛБАРТ ТУХАЙН ОРОН НУТАГ ДАХЬ МОНГОЛБАНКНЫ САЛБАРААС
ХЯНАЛТ ТАВИХАД БАРИМТЛАЖ АЖИЛЛАХ УДИРДАМЖ, ЧИГЛЭЛ**

Онцгой дэглэм тогтоосон банкны орон нутаг дахь салбарт тухайн орон нутаг дахь Монголбанкны салбараас хяналт тавихдаа дараахь удирдамж чиглэлийн дагуу ажиллана. Үүнд:

1.Тухайн орон нутаг дахь банкны салбар, нэгжийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварын байдалд үнэлэлт дүгнэлт өгч, сар тутам БЭТ-д албан ёсоор тайлагнах,

2.Зээлийн ангиллыг холбогдох журмын дагуу хийж, ЗТУБАХС-г зохих хэмжээнд нь бүрэн байгуулсан эсэхэд хяналт тавьж, биелэгдээгүй тохиолдолд газар дээр нь арга хэмжээ авч, гүйлгээг хийх,

3.Салбар, нэгжийн боловсон хүчний асуудалд хяналт тавьж, зөрчил дутагдал гаргасан, ажилдаа хариуцлагагүй, шударга бус хандсан салбарын захирал, ерөнхий нягтлан бодогч, эдийн засагчийг өөрчлөх, илүүдэлтэй орон тоог цөөрүүлэх, цомхотгох саналыг БЭТ-д танилцуулж шийдвэрлүүлэх,

4.Салбарын үйл ажиллагааны ерөнхий байдлын талаар БЭТ-д 14 хоногт 1 удаа утсаар мэдээлж байх,

5.Аливаа ашиглал, залилан мэхлэх үйл ажиллагаа гаргуулахгүй байх арга хэмжээ авч, банкны харуул хамгаалалтын байдлыг байнга хянах,

6.Зээлийн барьцаа, баталгаа хөрөнгийн үнэлгээг тогтооход санал өгч, бодитой байх зарчмыг баримтлах,

7.ӨБҮХХ-ийг газар дээр нь нүд үзэн шалгаж, үнэлгээ нь хэт өндөр тогтоогдсон, зах зээлд тухайн үнээрээ борлогдох боломжгүй хөрөнгийг зээлдэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр зээлийн дансанд буцаан бүртгэх тухай шийдвэрийг салбарын захиралд үүрэг болгох, өр барагдуулалтанд хяналт тавих,

8.Тухайн салбар, нэгж татан буугдсан тохиолдолд зээлийн өр барагдуулах төлөөлөгчөөр ажиллах ажилтныг сонгон ажиллуулахад санал өгөх,

9.Орон нутгийн шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны үйл ажиллагааны талаар БЭТ-өөр дамжуулан, Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий

газарт санал уламжлах,

10.БЭТ-өөс хүргүүлсэн албан тоот, тушаал, шийдвэрийн 1 хувийг хүлээн авч, биелэлтэд нь хяналт тавих,

11.Салбар, нэгжийг татан буулгах, үндсэн хөрөнгө, материалыг актлах, худалдан борлуулах үйл ажиллагаанд заавал биечлэн оролцож, БЭТ-д ирүүлэх тайланд тусгах.